

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ**

**ХАРЬЦАХ ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1 Энэ хуулийн зорилт нь орчин цагт болон ирээдүйд Монгол Улсын хүн ба хүрээлэн буй байгаль орчныг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хорт нөлөөллөөс хамгаалахад чиглэгдэн түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах тухай хууль тогтоомж**

2.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах тухай хууль тогтоомж тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Цөмийн энергийн тухай хууль, мөн энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Нэр томъёо**

Энэ хуулинд хугацаа, ойлголтууд доорхи утгаар хэрэглэгдэнэ:

3.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг үйлдвэрлэгчид гэдэг нь үйлдлийнх нь үр дүнд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал үүсдэг хуулийн этгээдийг хэлнэ.

3.2. Урт наст цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал гэдэг нь цөм, цацрагийн аюулгүй байдлын төрийн зохицуулалтын байгууллагын хяналтаас 300 жилээс их хугацааны дараа чөлөөлөгдөх цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлууд юм.

3.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг булах гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг ашиглах зорилгогүйгээр харьцахад зориулагдсан үйлдвэрт хадгалахыг хэлнэ.

3.4. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хадгалалт гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хүрээлэн буй байгаль орчноос тусгаарлах, хамгаалалт, цацрагийн шинжилгээ хийх боломжтой, мөн дахин боловсруулах, тээвэрлэх, булах ажиллагаа явуулдаг үйлдвэрт байршуулахыг хэлнэ.

3.5. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хүчгүйжүүлэх гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг өөр хэлбэрт шилжүүлэх, дурын матрицад оруулах, эсвээс герметик бүрхэвчинд байршуулахыг хэлнэ.

3.6. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хадгалах улсын кадастр гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хадгалах, булах, зориулалт бүхий үйлдвэрүүдийн тухай системчлэгдсэн мэдээллийн санг хэлнэ.

3.7. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг цомсгох гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, булах, бэлтгэлийн үйл явц юм. Уг үйл ажиллагааг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг контейнерт байршуулах эсвээс хүчгүйжүүлэх замаар хэрэгжүүлж болно.

3.8. Богино наст цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал гэдэг нь цөмийн болон цацрагийн аюулгүй байдал хариуцсан байгууллагын хяналтаас 300 жилийн дотор чөлөөлөгддөг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал юм.

3.9. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэр гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, хадгалах, булахад зориулагдсан төхөөрөмж, байр хэрэгсэл мөн түүнчлэн ашиглалтаас гарсан цөмийн төхөөрөмжийг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан төхөөрөмж гэж баталсны дараахийг хэлнэ.

3.10. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг боловсруулах гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын шинж чанарыг өөрчлөх замаар хөрөнгө хэмнэх эсвэл аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа юм.

3.11. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын урьдчилсан боловсруулалт, цомсгох үйл ажиллагаа, тээвэрлэлт, хадгалалт, булах үйл явцтай холбоотой бүх үйл ажиллагааны төрлүүд, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын урьдчилсан боловсруулалт, идэвхгүйжүүлэлт, цуглуулж ангилалт хийх явцууд юм.

3.12. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах үеийн цацрагийн аюулгүй байдал гэдэг нь ажилтан, хүн ам, хүрээлэн буй орчинд нөлөөлөх цацрагийн аюулгүй байдлын стандарт, тогтоосон хэв хэмжээ, дүрмээр зөвшөөрөгдсөн хязгаарлалтаас давахгүй байх мөн радионуклидыг хүрээлэн буй орчинд нэвчихээс хязгаарлахыг хэлнэ.

3.13. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал гэдэг нь ашиглагдахаа больсон радионуклид болон цацраг идэвхт бохирдолтын идэвхжил зөвшөөрөгдөсөн хэмжээнээс давсан материаллаг объект, субстанцыг хэлнэ.

3.14. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын улсын бүртгэл гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын үүсэл, химийн бүтэц, хэмжээ овор, шинж чанар, түүнчлэн тээвэрлэлт, хадгалалт, булалтын тухай тусгай хэлбэр загварын эрх зүйн бичиг баримтын бүхий л явцад дэс дараалсан бичилтийг хэлнэ.

3.15. Чөлөөлөлтийн түвшин гэдэг нь цөм, цацрагийн аюулгүй байдлыг зохицуулах улсын байгууллагаас тогтоосон идэвхийн ба цацраг идэвхит бохирдолтын хязгаарт, эсвээс уг хязгаараас доор байх үед цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг цөмийн болон цацрагийн улсын хяналтын байгууллагын хяналтаас чөлөөлөгдөж болох түвшинг хэлнэ.

3.16. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах тусгай төрөлжсөн үйлдвэрийн газар гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах, тээвэрлэх, хадгалах, булах тусгай зөвшөөрлийн дагуу дээрх үйл ажиллагаа гүйцэтгэдэг үйлдвэр нэгдэлийг хэлнэ.

3.17. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хадгалах газар гэдэг нь цацраг идэвхт үүсгүүрүүд нүүхээс хамгаалах инженер, геологи болон бусад саадаар заавал хангагдсан цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хадгалах эсвээс булах байгууламжыг хэлнэ.

3.18. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах үеийн хамгаалал гэдэг нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалд хавьтахгүй байхыг зорчих үйлдлийг цаг тухайд нь илрүүлж, таслан зогсооход мөн цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалд зөвшөөрөлгүй нэвтэрч ашиглахыг зогсооход чиглэгдсэн зохион байгуулалт, техникийн иж бүрдэл арга хэмжээг хэлнэ.

#### **4 дүгээр зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээний төрийн бодлогын үндсэн зарчим.**

4.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд төрөөс явуулах бодлогын үндсэн зарчмууд нь:

4.2. Ажилтан, хүн амын амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчныг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын нөлөөллийг Цөмийн энергийн газраас тогтоосон хэм хэмжээнд байлгах эрхэм зорилт юм.

4.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд төрийн хяналт, удирдлагын үүргийг заагласан байх.

4.4. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай хайрцах хүрээнд төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах урт хугацааны төрийн хөтөлбөр боловсруулж гүйцэтгэх.

4.5. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах төрийн хөтөлбөрийг 5 жил тутамд нягталж байх.

4.6. Практикт хүрч болох цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал үүсэх доод түвшинд хүргэх нөхцлийг хангах.

4.7. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалыг хяналтгүйгээр хуримтлуулахгүй байх.

4.8. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах төрийн хяналт шалгалтыг хангах.

4.9. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хадгалалтыг шинээр байршуулах шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар, Цөмийн энергийн газар, төрийн гүйцэтгэх засаглалын орон нутгийн байгууллага гаргах.

4.10. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хадгалалтын аюулгүй байдлыг үндэслэн хүрээлэн буй байгаль орчноос цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын найдвартай тусгаарлалыг баталгаажуулах.

4.11. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хог хаягдал үйлдвэрлэгчдэд тодорхой хугацаанд хадгалж дараа нь тусгай байгууллагад шилжүүлэх.

4.12. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал үйлдвэрлэгчид нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах тусгай байгууллагад уг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг шилжүүлтлээ аюулгүй байдлыг хариуцна.

4.13. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд олон улсын хамтын ажиллагаа явуулах

4.14. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд эрдэм шинжилгээний идэвхитэй үйл ажиллагаа явуулах.

## **5 дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээний ажлын санхүүжилт**

5.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах төрийн хөтөлбөрийг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах төрийн тусгай сангаас санхүүжүүлнэ.

5.2. Тусгай сан нь доорхи эх үүсвэрээс бүрдэнэ:

5.2.1.1. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал бий болгодог үйл ажиллагаатай үйлдвэр, албан газар, байгууллагуудаас зорилготойгоор татаж авах. Татах хэмжээг үүсгэсэн хог хаягдлын тооноос шууд хамааралтай тогтооно

5.2.1.2. нутаг дэвсгэр дээрээ цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал хадгалсан хугацаанд нь шууд хамааралтай хэмжээгээр үйлдвэр, албан газар, байгууллагуудад төлбөр тавих

5.2.1.3. бусад эх үүсвэрүүд

5.3. Тусгай санг байгуулах журам хэмжээ, сангийн хөрөнгө ашиглах журамыг Цөмийн энергийн газар тогтооно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХАРЬЦАХ ХҮРЭЭНД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ МЭДЭЛ**

**6 дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд Улсын их хурлын эрх мэдэл**

6.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд Улсын их хурлын онцгой эрх мэдэл:

6.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд төрийн бодлогын үндсийг тодорхойлох

6.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг тодорхойлох

6.4. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай дахин боловсруулах үйлдвэрийн газруудын эргэн тойронд, нутаг дэвсгэрт эрх зүйн журам, оршин суугч иргэдийнх нь статусыг тогтоох

6.5. Урт хугацааны цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг булах, хадгалалтын байршил, төсөл, барилга байгууламжын шийдвэр гаргах

**7. дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд Цөмийн энергийн комиссын эрх мэдэл**

7.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд дараах эрх мэдэл хамаарна

7.2. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээний төрийн бодлогын хэрэгжилтийг хангах

7.3. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах үед аюулгүй байдлыг улсын хэмжээнд зохицуулж, төрийн удирдлагын байгууллагыг байгуулах

7.4. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд төрийн хөтөлбөрүүдийн боловсруулалт, хэрэгжилтийг хангах

7.5. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрүүдийг ашиглалтаас хасах, ашиглалтанд оруулах, барих, төлөвлөх, байршуулах шийдвэр гаргах

7.6. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг улсын хил дамжуулан байршуулах журмыг тодорхойлох

7.7. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах тусгай санд хөрөнгө төвлөрүүлэх хэмжээ, ашиглах журмыг тогтоох

7.8. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хэм хэмжээ, дүрэм, стандартуудыг боловсруулж батлах журмыг тодорхойлох

7.9. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх

**8 дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд, төрийн гүйцэтгэх засаглалын орон нутгийн байгууллагуудын бүрэн эрх.**

8.1. Төрийн гүйцэтгэх засаглал, өөрийн удирдлагын орон нутгийн байгууллагууд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд өөрийн эрх мэдлийн хүрээнд:

8.2. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрийг өөрийн нутаг дэвсгэрт байршуулахад нийгэм эдийн засгийн хөгжил, оршин суугч иргэдийнхээ эрх ашгийг үндэслэх асуудлыг зохицуулах

8.3. нутаг дэвсгэртээ байрших цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын булах, хадгалах үйлдвэрийг хаах, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрүүдийн байршлын төсөл, барих үйл ажиллагаа ашиглалтаас гаргахад экологийн экспертизэд орлцох

8.4. өөрсдийн захиргаан дахь нутаг дэвсгэр дээр цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай холбоотой үйлдвэрийг хаах, ашиглалтаас гаргах, ашиглалтад оруулах, барих, талбай сонгох, төлөвлөх аль ч шатанд санал зөрчилдөөнийг арилгахын тулд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрийн бүхий л техникийн ахуйн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудаар хамтран ажиллах харилцах тухай цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах тусгай төрөлжсөн үйлдвэрүүдтэй хэлэлцээ байгуулах

8.5. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрийг ашиглалтаас гаргах, байршуулах, барих, булах, хадаглалтыг хаах төслүүдийн асуудлуудаар олон нийтийн сонголтийг зохион байгуулах

8.6. зайлшгүй тохиолдолд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрүүд байрлах орон зайн эргэн тойронд газар нутгийн цацрагын судлалгаа зохион байгуулах

8.7. цацрагын нөхцөл байдлыг хүн амд мэдээлэх

8.8. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрүүдийг ашиглалтаас гаргасны дараа эсвэл булалтын хадгалалтыг хаасны дараа тухайн нутаг дэвсгэрт цацрагын байдалд хяналт тавих

8.9. цацрагын ослын тохиолдолд үйлдвэр, албан газар, байгуулалтуудын үйл ажиллагааны бэлэн байдал, өөрийн нутаг дэвсгэр дэх хүрээлэн буй байгаль орчны хамгаалалт, хүн амын аюулгүй байдлын хангалтанд хяналт хэрэгжүүлэх

8.10. цацрагын ослын хор уршгийг арилгахад оролцох

8.11. зайлшгүй тохиолдолд хүн амыг нүүлгэн шилжүүлэх бэлэн байдлыг хангаж, түүнийг хэрэгжүүлэх

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХАРЬЦАХ ХҮРЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **9 дүгээр зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээний аюулгүй байдлын төрийн зохицуулалт**

9.1. Энэ зохицуулалтад үйл ажиллагааны дараах төрлүүд хамаарна:

9.2. цацраг идэвхт хог хаягдлын улсын тооллого цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай хадгалалт, булалтын болон түр хадгалах орон байрны төрийн кадастрыг явуулах

9.3. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрүүдийг байршуулах талбайг сонгох төсөл хайгуулын ажил

9.4. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах, ашиглах, ашиглалтаас гаргах, булалтын хадгалалтыг хааснаас дараах аюулгүй байдлыг хангах ажлын зохицуулалт, булалтын хадгалалтыг хаах

9.5. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалыг тээвэрлэх, хадгалах

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах үед аюулгүй байдлын төрийн зохицуулалтыг гүйцэтгэхэд:

Цөмийн энергийн газар газар

эрүүл мэндийн яам

дотоод хэргийн яам

Гүйцэтгэх засаглалын төрийн бусад байгууллагууд хууль тогтоомжийн дагуу цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тогтоосон хууль тогтоомжийн журмаар олгоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХАРЬЦАХ УДИРДЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД**

**Арав дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээн дэх төрийн удирдлагын байгууллагууд.**

10.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд төрийн удирдлагыг цөмийн энергийн комиссын тодорхойлсон төрийн гүйцэтгэх засаглалын байгууллагууд гүйцэтгэнэ.

10.2. Цөмийн эрчим хүчийг ашиглах хүрээний төрийн удирдлага, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээний төрийн удирдлага үйл ажиллагааны эдгээр хүрээнүүдийг ялган зааглах зарчмаар хэрэгжинэ.

10.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд төрийн гүйцэтгэх засаглалын байгууллага дараах үүрэг гүйцэтгэнэ:

10.4. Монгол улсад цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд техникийн нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлэх

10.5. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах төрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх

10.6. Аж үйлдвэр цөмийн эрчим хүч, анагаах ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудын цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах, тээвэрлэх, хадгалах, булаах ажлуудын зохицуулалт

10.7. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах.

10.8. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг тоолох төрийн тогтолцоог бий болгож ажиллагааг нь хангах.

10.9. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах зориулалт бүхий үйлдвэрүүдийг барих, ашиглах, ашиглалтыг гаргах, булаах хадгалах хаах ажлуудыг зохицуулах:

10.10. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал, цөмийн ажилласан түлшийг хадгалах шинэ байр байгуулах ажлыг зохицуулах:

10.11. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах хүрээнд эрдэм шинжлгээ, туршилт зохион бүтээх ажлыг зохицуулах

10.12. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах тусгай сангийн хөрөнгийг бий болгох, ашиглах журмыг боловсруулах:

10.13. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хамгааллын тогтолцооны тасралтгүй ажиллагааг тодорхойлж, бий болгон дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, түүнчлэн цуглуулах, дахин боловсруулах, тээвэрлэх, хадгалах булалтын хангалтад хяналт тавих (2000.05.15ны №747 iv(747 15) хуулиар 10 дугаар зүйлийн iii хэсэгт догол мөрөөр нэмэгдсэн)

10.14. Цөмийн эрчим хүчний ашиглалтын хүрээнд төрийн гүйцэтгэх засаглалын байгууллагын цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах ( цуглуулах, дахин боловсруулах, тээвэрлэх, хадгалах, техникийн циклийн хязгаарт) ажлуудыг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцагч тусгай төрөлжсөн үйлдвэрүүдэд шилжүүлэх үед хариуцана.



10.15. Төрийн удирдлагын дээрх байгууллагуудын эрх, үүрэг, хариуцлага нь хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

10.16. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хамгаалалтын тогтолцооны тасралтгүй,ажиллагааг тодорхойлж бий болгон дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах түүнчлэн цуглуулах, дахин боловсруулах,тээвэрлэх, хадгалах оршуулалтын .....хяналт тавих

10.17. Цөмийн эрчим хүчний ашиглалтын хүрээнд төрийн гүйцэтгэх засаглалын байгууллага цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах (цуглуулах, дахин боловсруулах, тээвэрлэх, хадгалах, техник –циклийн хязгаарлалт ) ажлуудыг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицагч тусгай төрөлжсөн үйлдвэрүүдэд шилжүүлэх үед хариуцна.

10.18. Төрийн удирдлагын дээрх байгууллагуудын эрх, үүрэг,хариуцлага нь хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХАРИЦАХ ҮЕИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ**

### **Арваннэгдүгээр зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах үеийн хуулийн этгээдийн үүрэг**

11.1 Үйл ажиллагааны зохих төрөлд цөм болон цацрагын аюулгүй байдлын төрийн зохицуулалтын байгууллагаас тогтоосон журмын дагуу завшөөрөл олгогдсон хуулийн этгээд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харцах эрх эдэлнэ.

11.2 цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах аль ч шатны ажил гүйцэтгэгч зөвшөөрөл эзэмшигчид доорх үүрэг хүлээнэ:

11.3 Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах зориулалт бүхий байгууламж, тоног төхөөрөмжийг төсөвлөх, талбай сонгох ,барьж байгуулах, ашиглах ,ашиглалтаас гаргах цаг үед аюулгүй байдлыг хангах:

11.4 Зайлшгүй тохиолдолд объектуудын аюулгүй байдлыг өндөржүүлэх зорилгоор практикт боломжийн бүхий .....хийхийн тулд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах зориулалт бүхий ажиллаж буй объектуудын аюулгүй байдлыг цаг тухайн үед нь дахин үнэлж байх:

11.5 Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах аюулгүй байдлын чанарын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжилтыг хангах

11.6 Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын тооллого хөтлөх

11.7 Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хамгаалалыг хангах

11.8 Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хадгалах эсвэл оршуулалтын газарт цацрагын үнэлгээ шинжилгээгээр хангах:

11.9 Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах зориулалтай объектуудын ажилд гарсан зөрчлийн тухай төрийн гүйцэтгэх засаглалын байгууллага, орн нутгийн өөрийн удирдлагын байгууллагад мэдээлэх:

Цацрагын осол, түүний хор уршгийг устгах арга хэмжээ авах:

Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах үеийн цацрагын ослоос учирсан хохирлыг өөрийн хөрөнгө эсвэл даатгалын байгууллагын хөрөнгөөр нөхөн төлөх чадвартай байх

**Арванхоёрдугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал үйлдвэрлэгчид тусгай төрөлжсөн үйлдвэрүүдийн хоорондын харилцаа**

12.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг оршуулах ажиллагааг тогтоосон хууль тогтоомжийн дагуу зохих зөвшөөрөл эзэмшисэн цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харицах тусгай төрөлжсөн үйлдвэрүүдэд явуулна.

12.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал г үйлдвэрлэгчид тогтоосон хэм хэмжээ, дүрэм стандартын дагуу цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харицах тусгай төрөлжсөн үйлдвэрүүдэд шилжүүлнэ: үйл ажиллагаах нь үр дүнд бий болсон цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг эзэмшигчид уг хог хаягдлыг шилжүүлсэн тухай бичиг үзэглэсэн цагаас эхлэн уг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал нь төрийн өмчид шилжтэл уг хог хаягдлын цацрагын хамгаалал, аюулгүй байдлын хариуцлагыг зөвшөөрөл эзэмшигчид хариуцана.

12.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын урьдчилсан боловсруулалт, хог хаягдлыг бий болгосон үйлдвэр байгууллагад зөвшөөрөл эзэмшигчид хэрэгжүүлж болно.

12.4. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал үүссэн үйлдвэр, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харицах төрөлжсөн тусгай үйлдвэр хоорондын харилцаа нь хууль тогтоомжийн дагуу гэрээний зарчмуудад тогтоогдоно.

**Арвангуравдугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харицах төрөлжсөн тусгай үйлдвэрүүд, төрийн гүйцэтгэх засаглал, өөрийн удирдлагын орон нутгийн байгууллагууд хоорондын харилцаа**

13.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцдаг төрөлжсөн тусгай үйлдвэрүүд өөрийн харъяа үйлдвэрүүдэд ажилтан, хүн ам, хүрээлэн буй байгаль орчны аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

13.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцдаг төрөлжсөн тусгай үйлдвэрүүд нь төрийн гүйцэтгэх засаглалын болон өөрийн удирдлагын орон нутгийн байгууллагуудтай зохих гэрээ хэлцэл байгуулна.

13.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын шинэ хадгалалтыг байршуулах талбайг сонгож баталснаас хойш 6 сарын хугацаанд гэрээ хэлцлийг байгуулна.

13.4. Үйлдвэрийг төлөвлөх, барих, ашиглах, ашиглалтаас гаргах, хаах аль ч шатны санлын зөрөлдөөнийг тогтоосон хууль тогтоомжийн журмаар арилгана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДЛЫН УЛСЫН ТООЛЛОГО**

### **Арвандөрөвдүгээр зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын улсын тооллого**

14.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалын улсын тооллогыг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хяналтгүй хуримтлалаас зайлсхийх, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын байршил, шилжилт, хадгалалт, булалтад шуурхай хяналт тавих зорилгоор явуулна.

14.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын улсын тооллогод:

14.3. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын улсын бүртгэл хөтлөлт

14.4. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын улсын кадастр

14.5. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалыг түр хадгалах байршлуудын жагсаалтын хөтлөлт

14.6. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ба цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын улсын кадастрын улсын бүртгэлд тогтмол нэмэлт, тухайн цаг үеийн өөрчлөлт орсныг хангах зорилгоор цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалт, хадгаламжинд улсын өмчийн бүртгэлийг тогтмол явуулна.

14.7. цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын тооллого, улсын хөрөнгийн бүртгэлийн журмын гүйцэтгэлд нь хяналт тавьдаг цөм, цацрагын аюулгүй байдлын улсын зохицуулалтын байгууллага гүйцэтгэнэ.

14.8. Төрийн өмчийн бүртгэлийг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах хүрээнд төрийн гүйцэтгэх засаглалын байгууллага зохион байгуулна.

### **Арвантав дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын улсын бүртгэл**

15.1 Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын улсын бүртгэлийг бий болгож, хөнгөлөлтийг нь зохион байгуулах ажлыг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах хүрээнд төрийн захиргааны байгууллага хүлээнэ. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын улсын бүртгэлийн дүрмийг цэг батлана.

### **Арванзургаа дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хадгалалтын улсын кадастр**

16.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын улсын кадастрт байршил, тоон ба чанарын тодорхойлолт, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалт, булалтын нөхцөл, хяналтын тогтолцооны системчлэгдсэн банк агуулагдах ёстой.

16.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын улсын кадастр нь хугацаагүй хадгалалтад хамаарна.

16.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын улсын кадастрын дүрмийг цэг батлана.

### **ДОЛООДУГААР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХАРЬЦАХ ЖУРАМ**

#### **Арвандолоо дугаар зүйл 17. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хадгалах, булах**

17.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг хадгалах, булах үйл ажилагааг зөвхөн үүнд тусгайлан зориулагдсан хадгалалтад явуулна.

17.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг хадгалах булах үед хүрээлэн буй байгаль орчныг байгалийн болон хиймэл саадуудын системээр тусгаарлалтаар хангана.

17.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын цацрагын аюулгүй байдлыг ердийн нөхцөлд цөм ба цацрагын аюулгүй байдлын хэм хэмжээ, дүрэм, стандартуудын мөрдөлтөөр хангана.

17.4. Байгалийн онцгой үзэгдлүүд (газар хөдлөлт, үер, хар салхи зэрэгтэй төстэй) ийн үед эсвэл ослын нөхцөлд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын цацрагийн аюулгүй байдлыг цөмийн ба цацрагын аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээ, дүрэм, стандартуудын

хязгаарлалтыг хэтрээгүй нь нотлогдох үйл явдлуудын болзошгүй сценарууд (зохиомж) ын шинжлэх ухааны үндэслэл бүхий төслийн шийдвэрээр хангана.

17.5. Удаан хугацаанд булах цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг геологийн тогтвортой формацид газрын гүнд зөвхөн хатуу хэлбэрээр цацрагийн аюулгүй байдлыг хангаж хадгалах шаардлагатай.

17.6. Булалтад орох цацраг нуклидын тоог цөм, цацрагын аюулгүй байдлын хэм хэмжээ, дүрэм, стандартуудаар зохицуулна.

17.7. Богино хугацаанд арилах хатуу байдалд байгаа цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг газрын хөрсний өнгөц болон дээр байрлах байгууламжид хадгалалж болно.

17.8. Дахин боловсруулалтад орохгүй ашиглагдсан цөмийн түлшийг зохих хугацаанд байлгасаны дараа ашиглагдсан цөмийн түлшийг хадгалах техник тоног төхөөрөмжөөр хангагдсан олон давхар саадтай хамгаалалтын болон тусгаарлалтын систем бүхий тусгай байгууламжид хадгална.

17.9. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал хадгалах, булах бүхий л хугацаанд уг хог хаягдлын хадгалалтын цацрагын нөхцөл байдал, хүрээлэн буй байгаль орчинд байнгын хяналт тавина.

#### **Арваннайм дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах үеийн хамгааллын хангалт**

18.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах үеийн хамгааллын хангалт нь байгууламжийн бүрэн бүтэн байдал, халдашгүй байдалд аливаа халдлага гарахыг цаг тухай үед нь илэрүүлж, таслан зогсоох, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал д хүрч, ашиглах, хадгалалтад зөвшөөрөлгүй нэвтрэхийг таслан зайлуулахад чиглэсэн зохион байгуулал, техникийн иж бүрдэл арга хэмжээ төлөвлөж, зохицуулж, хяналт тавих нэгдсэн тогтолцоог хангана.

18.2. Хэрэв хамгаалалтыг хангах арга хэмжээ аваагүй бол цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай холбоотой үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

18.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах үеийн хамгаалалтын зохион байгуулалтын журмыг хууль тогтоомжоор тодорхойлно.

18.4. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах үед хамгаалалтыг хангах үүргийг зөвшөөрөл эзэмшигчид хүлээнэ.

## **Арванесдүгээр зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг тээвэрлэх**

Хууль тогтоомжоор тогтоогдсон журмаар зохих зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тээвэрлэж болно.

Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын тээвэрлэлтийг батлагдсан хэм хэмжээ, дүрэм, стандартуудын дагуу тээврийн баглаат комплектоор гүйцэтгэнэ:

- Тээвэрлэх журам
- Ачаа илгээгч, тээвэрлэх, хүлээн авагчийн эрх үүрэг
- Аюулгүй байдлын арга хэмжээ
- Баглаа боодол, тээврийн хэрэгчлэлд тавих шаардлага
- Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тээвэрлэх үед зам тээврийн тохиолдолд авах арга хэмжээ
- Цацрагын болзошгүй ослын үр уршгийг таслан зайлуулах, арилгах арга хэмжээ
- хамгааллын арга хэмжээ

Украины дотоод хэргийн яам цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тээвэрлэх үеийн зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх иж бүрдэл арга хэмжээний тогтолцоог боловсруулна.

Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг агаар, төмөр зам, ус, авто тээврээр тээвэрлэх нөхцөл, дэглэмийг монгол улсын дотоод хэргийн яамны зохих албадтай зохицон хэлэлцэнэ.

Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тээвэрлэх үед заам тээврийн хэрэг явдлаас цацрагын осол үүссэн тохиолдолд түүнийг устгах, түүнчлэн ажилтан, хүн ам, хүрээлэн буй байгаль орчин материаллаг үнэи зүйлсийг хамгаалах хариуцлагыг, хэрэв тээвэрлэх тухай хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол ачаа илгээгч хүлээнэ.

## **Хорьдугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалын хадгалалтын байгууламжийн ашиглалт**

20.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын байгууламжийг ашиглалтыг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах эрхийн лицензээр эрхлэнэ.

20.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалт ашиглалтыг цацрагын хяналт хийгдсэнээр цөм ба цацрагын аюулгүй байдлын хэм хэмжээ, дүрэм, стандартуудад зохицуулан хэрэгжүүлнэ.

20.3. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын байршлын бүсүүд хүрээлэн буй байгаль орчны байдалд нь тавих хяналтыг цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын зөвшөөрөл эзэмшигчдэд тооцон үзнэ.

20.4. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал хадгалалтын ашиглалтын үеийн зөрчлийн тухай цаг үеийнх нь мэдээллийг төрийн гүйцэтгэх засаглал, өөрийн удирдлагын орон нутгийн байгууллагуудад өгөхийг зөвшөөрөл эзэмшигчдэд даалгана.

20.5. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтыг үр дүнтэй ашиглахад чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтээр зөвшөөрөл эзэмшигчдийг хангана.

20.6. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын нутаг дэвсгэрт болон ариун цэвэр, хамгаалалтын бүс дэх онцгой дэглэмийг хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

### **Хориннэг дүгээр зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан хадгалалах үйлдвэрийг барих талбайг сонгох шийдвэрийг батлах журам**

21.1Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцахад зориулагдсан үйлдвэр эсвэл цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын барилгын зөвшөөрөл авах ба талбайг батлуулах саналуудаа төрийн захиргааны байгууллага, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах хүрээнд уих, эсвэл цөмийн энергийн газраас тогтоосон хууль тогтоомжийн дагуу өгөх ба энэ тухай төрийн гүйцэтгэх засаглал, орон нутгийн удирдлагын байгууллагуудад мэдээлнэ.

- Хэлэлцүүлэгт өгөх шаардлагатай:
- Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах зориулалттай хадгалалт, үйлдвэрийн техникийн тодорхойлолт
  - Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах зориулалттай үйлдвэрийн байгууламж барих үндэслэл гаргах, түүний байршлын талбайг гурваас доошгүй хувилбараар гаргах
    - Талбайн аюулгүй байдалын төслийн судалгааны үе дэх мэдээллийн анализ,
    - Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах зориулалт бүхий үйлдвэр, хадгалалтын байршлын район дахь хүрээлэн буй байгаль орчны тодорхойлолт
      - Эдгээр хадгалалтын үйлдвэр хүн болон хүрээлэн буй байгаль орчинд үзүүлэх нөлөөний тухай дүгнэлт
      - Украины хүрээлэн буй байгаль орчны хамгаалал, цөмийн аюулгүй байдлын болон эрүүл мэндийн яамд, геологи, газар байгалийн ашиглалт, ус цаг уурын шинжилгээний улсын хороодын сануулга, дүгнэлтүүд

- Төрийн гүйцэтгэх засаглал, өөрийн удирдлагын тухайн орон нутгийн байгууллагуудын санал, сануулгууд

- Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах зориулалт бүхий үйлдвэр, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын байгууламжид зориулагдах талбайг сонгосон тухай шийдвэрийг украины дээд зөвлөл эсвэл сайд нарын танхим эрх мэдлийнхээ дагуу гаргана.

**Хоринхоёрдугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах зориулалттай үйлдвэр, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын төсөл хийлт, бхрьж ашиглалтад өгөх**

22.1. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцахад зориулагдсан үйлдвэр, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын төслийг туршлага, туршилт,, анилизаар батлагдсан технологи ашигласан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэм хэмжээ, дүрэм, стандартуудын дагуу гүйцэтгэнэ. (2000.04.20ны 24р зүйлийн i хэсэг)

22.2. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалтын төсөл нь аюулгүй байдлын 2 үнэлгээ заавал агуулсан байна.

- Хадгалалтын ашиглалтын үеийн үнэлгээ
- Хадгалалтын хаасны дараах үнэлгээ

Аюулгүй байдлын үнэлгээ нь болзошгүй онцгой нөхцлийн хөгжлийн сценаруудын (зохиомжын) анализ, аюулгүй байдлын шалгуурууд бүхий үр дүнгийн харьцуулалтуудыг агуулсан байна. Төсөлд хийсэн улсын экспертизийн дүн эерэг гарсан тохиолдолд хууль тогтоомжоор тогтоогдсон журмаар барилга байгууламжийн зөвшөөрөл олгогдоно.

Хадгалалт, үйлдвэрийг ашиглалтын зөвшөөрөл хууль тогтоомжийн журмаар олгогдсон нөхцөлд ашиглалтад оруулна.

**НАЙМДУГААР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХАРЬЦАХАД  
ЗОРИУЛАГДСАН ҮЙЛДВЭР, ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДЛЫН ХАДГАЛАЛТАД ЗОРИУЛЖ  
ГАРГАСАН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЭРХ ЗҮЙН ДЭГЛЭМ**



**Хорингурав дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцахад зориулагдсан үйлдвэр, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлын хадгалалтад зориулж газар олгох**

23.1.Дээрх зориулалтын газрыг төслөөр тодорхойлогдсон ашиглалт, нөөшлөлийн бүхий л хугацаанд газрын хууль тогтоомжийн дагуу олгоно.

**Хориндөрөв дүгээр зүйл. Дээрхи зориулалт бүхий олгогдсон нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааны төрлүүд**

12.1.Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал хадгалалтад зориулагдсан газрыг аж ахуйн эргэлтээс гаргаж, зэргэлдээ нутаг дэвсгэрүүдээс ариун цэвэр хамгааллын бүсээр тусгаарлана.

Ариун цэвэр хамгааллын бүсийн хүрээнд хориглох нь:

хүн ам нутаглах

ус, ой, газрын баялагын ашиглалтын бүх хэлбэр

тусгай зөвшөөрөлгүй эрдэм шинжилгээний судалгаа явуулах

бараа бүтээгдэхүүний чиглэлийн үйлдвэрлэл, хаа, ойн аж ахуйн үйл ажиллагааг болон нийгэм, олон нийтийн зориулалттай үйлдвэрүүдийн барилга байгууламж, тусгай зөвшөөрөлгүйгээр барихыг

цацрагын аюулгүй байдлын дэглэмийг хангаагүй бусад аливаа үйл ажиллагааг

**АРАВДУГААР БҮЛЭГ. Цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд төрийн бодлогыг нийгмийн асуудлууд**

**Хоринтав дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах зориулалт бүхий үйлдвэр, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал хадгалалтыг байршуулсан районд аж төрж эсвээс ажилладаг иргэдийн нийгмийн баталгаа.**

25.1. Дээрх бүсэд аж төрдөг ба ажилладаг иргэдэд эдгээр үйлдвэр хадгалалтаас учруулсан хор уршгийг нөхөн арилгуулах эрхээр баталгаа өгнө.

Ийм нөхөж төлбөрийн хэлбэр, хэмжээ, журмыг тодорхой тохиолдол бүрт украины сайд нарын танхим шийдвэрлэнэ.

**Хоринзургаа дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай ажилладаг ажилтны нийгмийн хамгаалал**

Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай ажилладаг ажилтны нийгмийн хамгаалал нь:

- Улсын эрүүл мэндийн даатгалд заавал даатгагдсан байх
- Тэтгэврийн насыг тодорхойлох, богиносгосон ажлын өдөртэй байх, ажлын хөлсний нэмэлт тооцуулах, зээл авах зэрэг ижил төстэй хамгаалалтууд эдлэх
- Хөнгөлөлтүүдийн хэлбэр хэмжээг украины хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд хууль тогтоомжийн зөрчилд хүлээлгэх хариуцлага**

**Хориндолоо дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах тухай хууль тогтоомжийг зөрчсөн буруутайд тооцогдох этгээдүүдийн хариуцлага хүлээх үйлдлүүд нь:**

зохих лицензгүйгээр цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах үедээ ажлыг аюулгүй гүйцэтгэх хэм хэмжээ, дүрэм, стандартуудын шаардлагыг зөрчих

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцахдаа лицензийн нөхцлийг үл биелүүлэх

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах хүрээнд зохицуулалт явуулдаг байгууллагуудын албан бичгийн шийдвэрийг үл биелүүлэх

улсын заавал хийлгэх экспертизийн хууль тогтоомжийн шаардлагыг зөрчих, дүгнэлтийг нь авч тооцоогүй байх

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ын хадгалалт, үйлдвэрүүдэд гарган өгсөн нутаг дэвсгэр дэх экологийн байдлын тухай хуурамч мэдээлэл гаргах, хүн амаас нуух

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах зориулалт бүхий үйлдвэр, цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал хадгалалтад ослоос урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах албан үүргээ үл биелүүлэх, түүнчлэн осолын тухай мэдээллийг нуун дарагдуулах

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг хүн амболон тухайлсан бие хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулах зорилгоор ашиглах

дээрх хадгалалт, үйлдвэрийг ажилтан, хүн ам, хүрээлэн буй байгаль орчны хамгааллыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэлгүйгээр ашиглалтад хүлээн авах

гэмтэлтэй төхөөрөмж нийлүүлэх, угсрах, ашиглалтад оруулах

эдгээр үйлдвэр, хадгалалтын төсөлд иж бүрдлээр орох төхөөрөмж, байгууламжгүйгээр ашиглалтад авах

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай ажилд зохих бэлтгэлгүй болон 18 нас хүрээгүй түүнчлэн эрүүл мэндээр эсрэг үзүүлэлт бүхий хүмүүсийг авах

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах үе дэх хамгааллын хангалтын шаардлагыг зөрчих

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал ыг украины зөвшөөрөлгүйгээр зөөж гаргах, украинд оруулах

цөмийн болон цацраг идэвхт хог хаягдал тай харьцах хүрээнд бусад зөрчил гаргасны талаар хариуцлага хууль тогтоомжоор тогтоогдсон болно.

## **АРВАН ХОЁР ДУГААР БҮЛЭГ. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХАРЬЦАХ ХҮРЭЭН ДЭХЬ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

**Хориннамдугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээн дэх олон улсын хамтын ажиллагаа**

Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээн дэх олон улсын хамтын ажиллагаа нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээнд ажилладаг олон улсын байгууллагууд, бусад улсуудтай туршлага солилцож, харилцан туслалцах үндсэн дээр олон улсын эрх зүйн хэм хэмжээнд зохицуулан явагдана.

Цөмийн болон цацраг идэвхт хог хаягдалтай харьцах хүрээн дэх олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс нь украин улс оролцдог олон улсын гэрээнүүдийн хэм хэмжээ байна.